

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

**ХӨДӨЛМӨРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ц.БАЯРМААГИЙН 2025 ОНЫ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1	2	3	4	5	6	7	
Зорилт 1. “ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БОДЛОГО, ЭРХЗҮЙН ОРЧНЫ САЙЖРУУЛАЛТ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.	Арга хэмжээ 1.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.	Шинэчлэн боловсруулсан баримт бичгийн тоо		Хуулийн үзэл баримтлалт батлагдаж, хуулийн төсөл боловсруулагдсан байна.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл, үзэл баримтлалын төслийг боловсруулах техникийн ажлын хэсгийг ГБХНХЯ-ны ТНБД-ын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/128 тоот тушаалаар байгуулж теслүүдийг боловсруулж, үзэл баримтлалын төслийг ХЗЯ-нд 2024 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн 01/1422 тоот албан бичгээр хүргүүлж батлуулсан. Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нэгдүгээрт, салбаруудын бодлогын уялдаа холбоог хангаж хөдөлмөр эрхлэлтийн баримжаатай болгох, хоёрдугаарт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний төрлийг нэмэгдүүлж, олон улсын жишигт хүргэх, хэрэглэгч төвтэй бүтэц, кейс менежментийн тогтолцоонд шилжүүлэх, гуравдугаарт, их өгөгдөл суурилсан хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн тогтолцоог бүрдүүлж, ажиллуулах, дөрөвдүгээрт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд үр	1-6 сар	

				<p>дүн, гүйцэтгэлд суурилсан төсвийн төлөвлөлт бүхий олон эх үүсвэртэй, тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэх, тавдугаарт, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, төрхувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхтэй холбоотой бодлогын шинэчлэлийн агуулгуудыг тусган ажиллаж байна.</p> <p>Хуулийн төслийг холбогдох 3 судалгааны хамт боловсруулан Засгийн газрын гишүүдээс санал авахаар 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 01/1870 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Мөн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр холбогдох материалын хамт 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 01/1886 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Мөн Европын холбооны Socieux+ төслийн санхүүжилтээр "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг шинэчлэн найруулах замаар хөдөлмөр эрхлэлтийн тогтолцоог боловсронгуй болгох" төслийг боловсруулан Европын холбооны хурлаар батлуулаад байна. Уг төслөөр Олон Улсын 2. зөвлөх Монгол Улсад хөдөлмөр эрхлэлтийн тогтолцоог сайжруулах чиглэлээр хамтран ажиллахаар төлөвлөж байна.</p>	
2.	Арга хэмжээ 1.2. Ажиллах хүчиний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын их хурлын чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллана.	Баримт бичгийн тоо	Хуулийн төсөл УИХ-д өргөн барьсан.	<p>Тус яам улсын хөгжлийн ург хугацааны бодлогын хэрэгжилтийг хангах, хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчиний хомсдолыг нөхөх зорилгоор гадаадын иргэдийг Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэхэд уян хатан бодлого баримтлаж байна. Тухайлбал гадаадын ажилтан авах бодлогод эдийн засгийн үйл ажиллагааны бүтээмж өндөртэй уул уурхай, олборлолт,</p>	1-6 сар

				мэдээлэл холбоо, санхүү даатгал, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбаруудад гадаад ажилтны тоо, хувь хэмжээг хязгаартай тогтоох, улмаар дотоодын ажиллах хүчнийг эдгээр салбарт тулхүү ажиллуулах, харин барилга, эрчим хүч, боловсруулах үйлдвэрлэл зэрэг бүтээн байгуулалтын салбаруудад гадаад ажилтны тоо, хувь хэмжээг хязгаарлалтгүй тогтоож, ажлын байрны төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг Засгийн газар тогтоон өгч байх шаардлагатай байгаа юм. Энэ дагуу Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, сөрчлөлтийг тусгахаар хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанд танилцуулан УИХ-д өргөн барьсан байгаа болно.	
3.	Арга хэмжээ 1.3. Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулна.	Засгийн газрын тогтоолын тоо	Засгийн тазрын 2025 оны “Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай” 31 дүгээр тогтоол	Үг хуулийн төсөл батлагдсанаар гадаад ажилтан авч ажиллуулах ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага, хөрөнгө оруулагчид гадаад ажилтны ажлын байрны төлбөрөөс хөнгөлүүлж, чөлөөлөгдөж, бизнес эрхлэлт, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, стратегийн ач холбогдол бүхий дэд бүтэц, үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, хөгжлийн төслийг хэрэгжүүлэхэд чухал аж холбогдолтой юм.	1-3 сар

				2025 онд гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусlamжийн хүрээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх болон стратегийн ач холбогдол бүхий дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэж байгаа байгууллагад ажиллах гадаад ажилтныг ажлын байрны төлбөрөөс чөлөөлүүлэх тухай салбарын яамдын хүсэлт, судалгаанд үндэслэн Засгийн газрын 2 удаагийн тогтоолын төслийг боловсруулж, яамдын саналыг авч нэгтгэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан. Уг тогтоолоор 54 аж ахуйн нэгж, байгууллагын 14952 гадаад ажилтныг ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх шийдвэрийг гаргуулсан.	
Зорилт 2. "ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО, ШИЙДВЭР, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ"					
1.	Арга хэмжээ 2.1 Бүс, орон нутгийн хөгжил болон эдийн засгийн төргүүлэх салбарын бүтээн байгуулалтын ажлын ажиллах хучний хөрөгцээг хангах салбар дундын хөдөлмөр эрхлэлтийн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Шийдвэр бүхий баримт бичиг		Aймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулах 2025 онд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хууль тогтоомж, бусад баримт бичигт заасан эрх хэрэгжүүлж, үүрэг гүйцэтгэх гэрээнд дараах арга хэмжээг тусган хамтарч ажиллаж байна. Үүнд: <ul style="list-style-type: none">- Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн төлөв байдлыг здийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлийн байдлаар нарийвчлан судлан тодорхойлж, хүний иөөцийн оновчтой төлөвлөлт, хуваарилалтын зорицуулалтыг хийж ажиллана;- Техник технологийн хөгжил дэвшилд тулгуурласан бүтээмж өндөртэй, инноваци шингэсэн шинэлэг санал санаачилгыг дэмжих, холбогдох териин болон хувийн хэвшлийн байгууллагатай хамtran ажиллахад нь дэмжлэг үзүүлнэ;- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний	1-6 сар

төв (job center)-ийг орон нутагт нээн ажиллуулах, дэмжлэг үзүүлнэ;

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжилт авсан ААНБ, иргэдийн бараа бүтээгдэхүүнд борлуулалтын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг шинэ төвшинд гаргаж, арга барилыг сайжруулж шинэчлэх, томоохон ААНБ-тай гэрээ байгуулж, борлуулалт хийх, хамтран ажиллах гарцыг бий болгоно;

- Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3 дахь заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 43.3 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангуулж, төвлөрсөн хөрөнгийг орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулах үйл ажиллагаанд зориулалтын дагуу зарцуулна зэрэг болно.

Мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа /хөтөлбөр/-ны хэрэгжилтийг хангуулахад шаардагдах суурь судалгаа, мэдээллийг шинэчлэн бий болгох зорилгоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгцээний судалгаа”-г аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдээр дамжуулан гүйцэтгэсэн.

Тус судалгаагаар засаг захиргааны нэгж тус бүрээр ажилгүй иргэний бүртгэл, судалгаа гарч, улмаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйчилгээ, арга хэмжээнд хамрагдах хүсэлт, хэрэгцээний талаарх тодорхой мэдээлэл бий болсон ба тус мэдээллийг ХЭДС-ийн төсвийн хуваарилалтыг оновчтой, бодитой болгох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийг сайжруулах суурь мэдээллээр ашиглаж байна.

2.	<p>Арга хэмжээ 2.2</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээг гүйцэтгэлийн үр дүн, чанарт суурилсан байдлаар шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллана.</p>	<p>Шийдвэр бүхий баримт бичиг</p>		<p>2025 онд хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны төсөлд яамны дотоод нэгжийн газрууд, ХХҮЕГ, аймаг, дүүргийн ХХҮ-ний газар, хэлтсийн төлөөлөл, МАОЭНХ, МҮЭХ, МҮХАҮТ-ийн төлөөлөл, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ийн төлөөлөл, Монголын Хувийн хөдөлмөрийн биржүүдийн нэгдсэн холбооны удирдлага болон ЖобЦэнтр төвийн ажилтнуудын төлөөлөлүүдтэй уулзалт, хэлэлцүүлэг хийж холбогдох саналыг авсан.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ болон төслийг хамтран боловсрууяж 2025 оны 2 дугаар сарын 11-ний Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Энэ хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн сургалтын үйл ажиллагаа, санхүүгийн дэмжлэгийн үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, түр ажлын байрыг дэмжих болон ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа гэсэн 5 үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, мөн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тодорхойлсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад туршилтын төсөл, үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолыг үндэслэн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/50 дугаар тушаалаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамж,</p>
----	---	-----------------------------------	--	---

				зардлын жишиг хэмжээг батлан хэрэгжүүлж байна.		
3.	Арга хэмжээ 2.3 Хилийн чанадаас эх орондоо эргэн суурьших Монгол иргэдэд чиглэсэн цогц хөтөлбөр батлуулж хэрэгжүүлнэ.	Судалгаа, мэдээллийн тоо	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны төлөвлөгөө	<p>НҮБ-ын Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллагатай гадаадад ажиллаж, амьдарч байгаа Монгол иргэд болон Монгол улсад ажиллаж байгаа гадаадын ажилчдын асуудлаар хамтран ажиллах чиглэлээр санал солилцон хамтран ажиллаж байна. Тус байгууллагын гадаадад суралцаж, ажиллаж байгаа өндөр ур чадвартай иргэдийг эх орондоо эргэн ирэх, хөдөлмөр эрхлэхэд нь дэмжих чиглэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа судалгаа, туршилтын хөтөлбөрийн ажлын даалгавартай танилцсан санал хүргүүлсэн.</p> <p>Мөн хоёр улсын Засгийн газар хооронд байгуулсан санамж бичгийн дагуу БНСУ болон Япон улсод хууль ёсоор хөдөлмөр эрхэлж байгаа, нутаг буцах хугацаа нь дэжсэн иргэдийн судалгаа, мэдээллийг гаргах, хөдөлмөр эрхлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, холбогдох дэмжлэгийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр холбогдох судалгааг хийж байна.</p> <p>Бичил, жижиг бизнес эрхлэгчдэд бизнесийн үйл ажиллагаагаа хөгжүүлэхэд зориулсан зээл, санхүүтийн дэмжлэгийг өргөтгэж, хүртээмжийг нэмэгдүүлэхээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6.3.8 дахь заалтын хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэн хэрэгжүүлэх “Хөгжлийн гүүр” хөтөлбөрийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж дэмжсэн. Уг төсөлд гадаадаас эх орондоо эргэн ирсэн иргэний үүсгэн байгуулсан аж ахуйн нэгж,</p>	1-6 сар	

					байгууллагыг хамруулах юм.		
4.	Арга хэмжээ 2.4 "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын хөтөлбөрийг боловсруулж, батлуулж, хэрэгжүүлнэ.	Шийдвэр бүхий баримт бичиг		Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны төлөвлөгөө	<p>1. Бичил, жижиг бизнес эрхлэгчдэд бизнесийн үйл ажиллагаагаа хөгжүүлэхэд зориулсан зээл, санхүүгийн дэмжлэгийг өргөтгэж, хүртээмжийг нэмэгдүүлэхээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6.3.8 дахь заалтын хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэн хэрэгжүүлэх "Хөгжлийн гүүр" хөтөлбөрийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж дэмжсэн. Уг төсөлд гадаадаас эх орондоо эргэн ирсэн иргэний үүсгэн байгуулсан аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулах юм.</p> <p>2. Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан "Олон Улсын жишигт нийцсэн хөдөлмөрийн бирж, нийгмийн үйлчилгээний үндэсний платформыг нэвтрүүлж, тер, хувийн хөвшлийн түншлэлээр дамжуулан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хүртээмжтэй болгох" зорилтын хүрээнд улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг олон улсын жишигт нийцсэн байдлаар үзүүлэх, ижил стандарт бүхий "Job center" төвүүдийг байгуулахаар төлөвлөж, Улаанбаатар хотод 2024 онд эхний 4 төвийн үйл ажиллагааг эхлүүлсэн. Мөн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар "Job center" туршилтын төсөл"-ийг хэлэлцэн баталсан. Энэхүү төслийн хүрээнд 2025 онд улсын хэмжээнд 30 төвийг шинээр байгуулж, 50-иас доошгүй хувийг эдийн засгийн үйл ажиллагааны салбар болон хүн амын бүлгүүдээр төрөлжүүлэхээр төлөвлөсөн.</p>	1-6 сар	

				<p>2025 оны эхний хагас жилийн байдлаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2025 оны А/196 дугаар тушаалаар орон нутагт 3 төв /Хэнтий, Хөвсгөл, Дорнод аймаг/, Улаанбаатарт 4 төв шинээр байгуулах бэлтгэл хангагдсан.</p> <p>Азийн хөгжлийн банкны “Мэдлэгт тулгуурлан төсөлд инноваци, туршлагыг нэвтрүүлэх нь” техник туслалцааны төслийн хүрээнд төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хөгжүүлэх, “Job Center” төслийг амжилттай, үр дүнтэй хэрэгжүүлэхэд олон улсын зөвлөх ажиллуулах хүсэлтийг 2024 оны 12 дугаар сард Азийн хөгжлийн банканд хүргүүлсэн. Улмаар АХБ-ны сонгон шалгаруулалтаар сонгогдоон Олон Улсын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний сүлжээнд харьяалагддаг мэргэшсэн 2 зөвлөх 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 06-ны өдрийн хугацаанд Улаанбаатар хотод ажилласан. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний баг ГБХНХЯ, ХХҮЕГ, Хан-Уул дүүргийн ХХҮХ, Жоб Центр төв, МҮЭХ, МҮХАҮТ, МСҮТ-ын холбогдох төлөөлөл, ILO, JAICA, GIZ зэрэг олон улсын байгууллагуудтай санал солилцох уулзалтуудыг хийсэн.</p> <p>Төслийн хүрээнд Олон Улсын хууль эрх зүйн орчин, Job center төвийн статус, тоо хэмжээг зохицтойгоор тогтоох, төлөвлөлт, хэрэгжилтийн шатны уялдаа холбоог сайжруулах чиглэлээр зөвлөмж авах юм. Зөвлөх үйлчилгээний ажлын эхний дүгнэлт, санал зөвлөмжүүд гарсан ба эцсийн тайланг 2025 оны 6 дугаар сард багтаан танилцуулахаар төлөвлөсөн.</p>	
--	--	--	--	--	--

Зорилт 3. “ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХҮРЭЭНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ ДОТООД АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ”

1	Арга хэмжээ 3.1. Төрийн жинхэнэ албан хаагчид хамаарах дотоод ажил, үйлчилгээг хэрэгжүүлэх	ирүүлсэн албан бичиг, өргөдлийн хариу ёгсэн хувь		100%	Хариуцсан ажил үүрэгтэй холбоотой асуудлаар ААНБ, иргэнээс ирүүлсэн албан бичигт хариу хүргүүлж, шийдвэрлэж ажилласан. Хэрэгжилт-100%	1-6 сар	100
2	Арга хэмжээ 3.2. Бусад дотоод ажил, үйлчилгээ	нэгтгэн боловсруулсан төлөвлөгөө, тайлангийн тоо		Тайлан-1	Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлтийг боловсруулахад удирдлагаар хангаж, хянаж боловсруулсан, удирдлагад танилцуулж ТЗҮГ-т хүргүүлсэн Төлөвлөгөө-1 Тайлан-1	1 сар	100

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1.	Зорилтот бүлгийн иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ хэрэгжүүлнэ.			Холбогдох асуудлаар бодлогын газруудтай хамтарч ажиллана.	- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 2 дугаар сарын 20-ны А/57 дугаар тоот тушаалаар “ЖАЙКА” Олон улсын хөгжлийн байгууллага хамтран хэрэгжүүлэх “Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар бие даан амьдрахад дэмжилэг үзүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийн Удирдах хорооны тшигүүдийн бүрэлдэхүүн, төслийг хэрэгжүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг тус тус батлуулсан. Төслийн хүрээнд “Ажил турших хөтөлбөр”-г туршиж, төслийн загварыг сайжруулан Дундговь аймаг, Баянзүрх, Сүхбаатар дүүргүүдэд хэрэгжүүлж байна. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний зөвлөхүүдийг бэлтгэх, чадавхижуулахтай холбоотойгоор Япон улсад 8 ахлах зөвлөх туршлага	1-6 сар	

					судлан чадавхижих хөтөлбөрт хамрагдсан. Дотоодын зөвлөхүүдийг бэлтгэх сургалтын арга хэмжээг зохион байгуулж 50 хүн хамрагдсан.		
2.	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар цогц судалгаа хийж, бодлого, үйл ажиллагааг сайжруулна.				<p>- Монгол Улсын залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг оновчтой тодорхойлж, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын санхүүжилттэй Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих YEP төслийг хэрэгжүүлж эхлээд байна. Энэхүү төслийн хүрээнд залуучуудын хөдөлмөр эрхлэлтэд тулгамдаж буй асуудлуудад дүн шинжилгээ хийж, хүний нөөцийн бодлого, бүтээмж, ажлын байрны менежментийг сайжруулах арга хэрэгслийг түгээн дэлгэрүүлж, холбогдох сургалтуудыг зохион байгуулж ажиллах бөгөөд ноос тооцуур болон зочлох үйлчилгэсний салбарт туршин хэрэгжүүлэх юм.</p> <p>- Азийн хөгжлийн банкны “Мэдлэгт тулгуурлан төсөлд инноваци, туршлагыг иштрүүлэх нь” тохник туслалцааны төслийн дэмжлэгтэйгээр Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн асуудлаарх судалгааны ажлыг хийхээр Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн А/156 дугаар тушаалаар ажлын хөсөг байгуулсан. Энэхүү судалгааг 2025 оны 7 дугаар сард багтаан дуусгах бөгөөд 9 дүгээр сард хийхээр төлөвлөсөн Залуучуудын нэгдсэн форумд танилцуулна. Нэгдсэн форумаар залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн нехцел байдал, тулгамдаж буй асуудал, цаашдын чиг хандлагын талаар хэлэлцүүлэг хийж, хэлэлцүүлгээс гарсан асуудлыг бодлогын баримт бичигт тусгаж, хууль эрхзүйн орчны хүрээнд мөн</p>	1-6 сар	

					хэрэгжилтийн түвшинд шийдвэрлэж ажиллахаар төлөвлөж байна.		
3	Эхчүүд, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, арга хэмжээ хэрэгжүүлнэ.				Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусlamжаар хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа "Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих" төслийн төлөвлөлтийн ажилд санал өгч, төслийг дизайн боловсруулах ажлыг хамтран гүйцэтгэж байна.		

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	5	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1	2	3	4	6	7			
1.	Арга хэмжээ 1. Холбогдох хууль тогтоожийн күрээнд мэдлэг, ур чадвараа дээшлүүлнэ.	1-ээс дээш сургалт, семинарт хамрагдах.			<ul style="list-style-type: none"> - Яамнаас зохион байгуулсан албан хаагчдыг чадавхижуулах уулзатт, сургалтад тухай бүр хамрагдсан. - Удирдлагын академиас зохион Байгуулдаг төрийн албаны "Ахлах түшмэл"-н сургалтанд хамрагдан 2025 оны 2 дугаар сарын 27-ны өдөр амжилттай төгссөн. - 2025 оны 2 дугаар сард Жендерийн үндэсний хорооноос зохион байгуулсан "Азийн эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөр"-т хамрагдан чадавхи бэхжүүлсэн. 		100	

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН
ХЭЛСИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
(Албан тушаал)

Ц.БАЯРМАА / /

(Нэр, гарын үсэг) (Огноо)

**ХӨДӨЛМӨРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
ЦЭРЭНДОРЖ ОВОГТОЙ БАЯРМААГИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
(ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)**

Байгууллагын нэр: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Нэгжийн нэр: Хөдөлмөрийн бодлогын газар, Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж , дахин үнэлсэн оноо
					5
Оноо					
		60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	

**Зорилт 1. “Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, эрхзүйн орчныг сайжруулах ажлын хүрээнд...”
хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт**

1.	Арга хэмжээ 1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.	60	9	69	69
2.	Арга хэмжээ 1.2. Ажиллах хүчиний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын их хурлын чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллана.	60	10	70	70
3	Арга хэмжээ 1.3. Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулна.	60	10	70	70

Зорилт 2. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, шийдвэр, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд” хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт

1.	Арга хэмжээ 2.1. Бүс, орон нутгийн хөгжил болон эдийн засгийн тэргүүлэх салбарын бүтээн байгуулалтын ажлын ажиллах хүчиний хэрэгцээг хангах салбар дундын хөдөлмөр эрхлэлтийн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлнэ.	60	9	69	69
2	Арга хэмжээ 2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээг гүйцэтгэлийн үр дүн, чанарт	60	10	70	70

	суурилсан байдлаар шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллана.			
3.	Арга хэмжээ 2.3. Хилийн чанадаас эх орондоо эргэн суурьших Монгол иргэдэд чиглэсэн цогц хөтөлбөр батлуулж хэрэгжүүлнэ.	58	8	66
4	Арга хэмжээ 2.4. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.	60	9	69
Зорилт 3. “Төрийн албан хаагчийн хүлээсэн үүргийн хүрээнд хийж гүйцэтгэх дотоод ажил үйлчилгээ”-г хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт				
1.	Арга хэмжээ 3.1. Төрийн жинхэнэ албан хаагчид хамаарах дотоод ажил, үйлчилгээг хэрэгжүүлэх	60	10	70
2	Арга хэмжээ 3.2. Бусад дотоод ажил, үйлчилгээ	60	10	70
Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт				
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Зорилтот бүлгийн иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ хэрэгжүүлнэ	58	8	66
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар цогц судалгаа хийж, бодлого, үйл ажиллагааг сайжруулна.	60	8	68
3.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Эхчүүд, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, арга хэмжээ хэрэгжүүлнэ.	58	8	66
Дундаж оноо:			68,6	68,6

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
				1
1.	Арга хэмжээ 1. Холбогдох хууль тогтоожийн хүрээнд мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх	100	15	15
Дундаж оноо			75	75

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
			1
1.	Хандлага, ёс зүй	7	7
2.	Дүн шинжилгээ хийх	7	7
3.	Асуудал шийдвэрлэх	6	6
4.	Хариуцлагатай байдал	7	7

5.	Ажлын цаг ашиглалт	<i>7</i>	<i>7</i>
	Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
6.	Мэргэжлийн ур чадвар 1.	<i>7</i>	<i>7</i>
7.	Мэргэжлийн ур чадвар 2.		
8.	Мэргэжлийн ур чадвар 3.		
	Дундаж оноо	<i>6,8</i>	<i>6,8</i>

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	<i>2</i>
1.	Хандлага, ёс зүй	<i>8</i>
2.	Багаар ажиллах	<i>7</i>
3.	Харилцаа	<i>8</i>
	Дундаж оноо	<i>7,7</i>

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлтт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	(70 хүртэлх оноо) <i>68,6</i>
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	(15 хүртэлх оноо) <i>15</i>
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн дарын үнэлгээ)	(7 хүртэлх оноо) <i>6,8</i>
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	(8 хүртэлх оноо) <i>7,7</i>
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгийн холбогдох заалтыг бичих)	(.... оноо)
	Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн дарын хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хэссэн оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо	<i>98,1</i>

Үнэлгээ өгсөн:

Хөдөлмөрийн бодлогын
газрын дарга
(албан тушаал)

Нэгжийн дарга


(гарын үсэг)

X. Тамир

/...../.....
(албан хаагчийн нэр)

2025.06.09. (огноо)

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**

ХХ-ийн баргуяа албан
үүрэгийн даргаан түүрээгээг
(албан тушаал)

Төрийн жинхэнэ албан хаагч:


(гарын үсэг)


Т. Бадринат
(албан хаагчийн нэр)
2025.06.09

..... (огноо)

Үнэлгээс хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

.....
(албан тушаал)


(гарын үсэг)

1. В. Мувшиштаал
(албан хаагчийн нэр)

2015.06.20... (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

.....
(албан тушаал)



(гарын үсэг)

1. В. Мувшиштаал
(албан хаагчийн нэр)

2015.06.20... (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирбагч

.....
(албан тушаал)


(гарын үсэг)

1. В. Монхзүр
(албан хаагчийн нэр)

2015.06.20... (огноо)

